



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 2/217

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн 4 том туулийн нэг, Монголын эртний утга зохиолын гурван оргилын нэг болох “Жангар” туулийг ард иргэдэд сурталчлан таниулах, залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор Монголын театр урлагийн байгууллагаас анхлан “Дуулалт жүжиг” болгон тайзнаа амилуулж, нутгийн зон олондоо толилуулсан Хөгжимт драмын театрын дуучин Б.Одгэрэл, Б.Даваажаргал, Д.Алтансүх, хөөмийч Д.Золзаяа, хөгжимчин Б.Наранчимэг нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 150000 төгрөг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 150000 төгрөг /Нэг зуун тавин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02.01078
D/Zax-A/217-Да

Аймгийн Засаг даргын 2019 оны
04 дүгээр сарын 04-ны өдрийн
А/217 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ БОЛОН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Б.Одгэрэл	Хөгжимт драмын театрын дуучин	30000
2	Б.Даваажаргал	Хөгжимт драмын театрын дуучин	30000
3	Д.Золзаяа	Хөгжимт драмын театрын хөөмийч	30000
4	Д.Алтансүх	Хөгжимт драмын театрын дуучин	30000
5	Б.Наранчимэг	Хөгжимт драмын театрын хөгжимчин	30000
Дүн			150 000

-оОо-